



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 04 сарын 19 өдөр

Дугаар А/187

Чингис хот

Коронавирусын халдвар /ковид-19/
цар тахлын болзошгүй эрсдэлийг бууруулахад
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.20, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3 дахь заалт, Аймгийн онцгой комиссын 2020 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 37 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Коронавирусын халдвар /ковид-19/ цар тахлыг илрүүлэх шинжилгээнд шаардлагатай PCR шинжилгээний вирус тээвэрлэх орчин бүхий хуруу шилийг худалдан авахад зориулж хөрөнгө зарцуулсугай.
2. Хөрөнгө зарцуулалтын тооцоог хавсралтаар баталсугай.
3. Дээрх зардалд шаардагдах 5.400.000 /таван сая дөрвөн зуун мянган/ төгрөгийг Гамшгийн эрсдэлийг бууруулах сангаас зарцуулахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /С.Нямдаваа/-т зөвшөөрсүгэй.
4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Ц.Чогсомжав/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

231011963

04 Аймгийн Засаг даргын 2021 оны
... дугаар сарын ... өдрийн ...
дугаар захирамжийн хавсралт

Зардлын тооцоо

№	Нэр төрөл	Хэмжих нэгж	Нэгж үнэ	Тоо хэмжээ	Дүн
1	Вирус тээвэрлэх орчин бүхий хуруу шил, ариун бамбарын иж бүрдэл	ш	1,800	3000	5.400.000.0
	НИЙТ ДҮН				5.400.000.0